

Монгол улсын Гадаад харилцааны дэд сайд Эрхэмсэг хатагтай
Б.Батцэцэг,
Эрхэм хүндэт Хатагтай ноёд оо,

Юуны өмнө өнөөдөр Япон, Монгол хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ойг тохиолдуулан ийм гайхамшигтай хүлээн авалтыг зохион байгуулж буй ГХ-ны сайд Эрхэмсэг ноён Ц.Мөнх-Оргил Танд талархаж буйгаа илэрхийлье. Мөн энэхүү баярт үйл явдлыг тохиолдуулан цаг зав гарган хүрэлцэн ирсэн та бүхэнд талархал илэрхийлье.

45 жил бол ер бусын өөрчлөлт хувиралтаар дүүрэн түүхийн хангалттай урт хугацаа билээ. Одоогоос 45 жилийн өмнө манай анхдагчид хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоох шийдвэр гаргах тэр үед, өнөөдөр бидний тогтоогоод буй ийм нягт хэлхээ холбоо, бие бие рүүгээ чиглэсэн элэгсэг дотно харилцааг буй болгож чадна хэмээн төсөөлж байсан нь тун цөөн байсан болов уу.

Өнгөрсөн 7 сард Ерөнхий сайд Ш.Абэгийн Улаанбаатар хотноо хийсэн 3 дахь удаагийн айлчлал нь Япон улс Монгол улстай харилцах харилцаандаа нэн өндөр ач холбогдол өгдөгийн бэлэг тэмдэг юм. Япон, Монгол хоёр улс ардчилал, бүс нутаг дахь энх тайван, хөгжил цэцэглэлтийг хөхиүлэн дэмжих нийтлэг сонирхол зэрэг суурь үнэт зүйлсийг хуваалцдагийн хувьд Стратегийн түншлэлийг тогтоогоод байгаа билээ. Тийм ч учраас Япон улс Монгол улсын бие даасан хөгжлийг дэмжих гэж үлэмж их хүчин чармайлт гаргадаг юм.

Миний бие энэ албыг хүлээн авснаас хойшхи 2 сар орчимын хугацаанд Японы оролцоо бүхий хэд хэдэн хөгжлийн төсөл, тухайлбал Япон-Монголын сургалтын эмнэлэгийг барих төсөл, Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх онгоцны буудлын төсөл, Улаанбаатар хотын дулааны 4 дүгээр цахилгаан станцын

засварын төсөлтэй танилцлаа. Эдгээр төслүүд нь бүгд Монгол улсын үндэсний хөгжилд нэн чухал ач холбогдолтой. Үүний сацуу, өнөөг хүртэл бид “Өвсний үндэс” хөтөлбөрийн хүрээнд сургуулийн засвар, эмнэлэгийн шинэчлэл зэрэг ард иргэдийн амьдралд ашиг тусаа өгөхүйц 500 гаруй төслийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлээд байна.

Япон, Монгол хоёр улсын харилцааны нэгэн онцлог бол парламентаас орон нутгийн засаг захиргаа, боловсрол, шинжлэх ухаан урлаг, соёл, спорт, аялал жуулчлал зэрэг бүхий л салбарт маш өргөн цар хүрээний хүмүүсийн дэмжлэгийг авдагт оршино. Энэ утгаараа монголчууд Сүмо бөхийг хөгжөөн дэмжигч япончуудын хамт сүүлийн 19 жилд төрсөн анхны япон Ёкозүна болсон Кисэносатог халуун дотноор хүлээн авсан нь нэн талархуштайг дурдах нь зүйтэй болов уу.

Ойрын хугацаанд Японы парламентын Төлөөлөгчдийн танхимын даргын урилгаар УИХ-ын дарга Эрхэмсэг ноён М.Энхболд Япон улсад айлчлахаар төлөвлөж байгаагийн зэрэгцээ хоёр улсын хоорондын харилцан ашигтай харилцааг улам бүр гүнзгийрүүлэхэд чиглэсэн шинэ хөтөлбөрийг батлуулахаар төлөвлөөд байна.

Дээр дурдсан хоёр улсын гайхалтай харилцаа нь Япон, Монгол аль аль талын холбогдох хүмүүсийн олон жилийн нэр их хөдөлмөр, тууштай итгэл үнэмшлийн үр дүн юм. Иймд өнөөдрийн арга хэмжээг жинхэнэ утгаар нь баяр болгоход жинтэй хувь нэмэр оруулсан бүх хүмүүст дахин талархал илэрхийлье.